



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭДЭД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.11.19 № 03/2164
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зарласан Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх БОАЖЯ/20240101067 дугаартай Улсын болон орон нутгийн өмчит байгууллагын усан халаалтын зууханд техникийн шинэчлэлт хийх ажлын тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгад захиалагчаас өгсөн хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	Энэ тендер шалгаруулалтын үйлчилгээний хураамж төлсөн тендер шалгаруулалтын сонирхогч нь “AAA групп” ХХК тул та бүхэн энэ нэрээр бүртгэж, харьцаж байна уу? (урьдах шалгаруулалтад “AAA” ХХК оролцож байсан)	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт зааснаар Тендер шалгаруулалтад аж ахуй эрхлэгч дангаараа, эсхүл түншлэлээр тендер ирүүлж болно.
2	Тендер шалгаруулалтын баримт бичгийн “Техникийн тодорхойлолт”-ын 8-ын 3-т (тусгай шаардлага ба нөхцөл) ... Тухайн газар суурилуулах хийн болон цахилгаан зуухны нийлбэр чадал нь ажлын даалгаварт заасан утгаас бага байж болохгүй ... гэснийг хийн болоод цахилгаан зуухны нийлбэр чадал нь гэж ойлгох уу? Эсвэл хийн болон цахилгаан зуух тус тусдаа нийлбэр чадал нь ажлын даалгаварт заасан утгаас бага байж болохгүй гэж ойлгох уу?	Тендер шалгаруулалтын баримт бичгийн “Техникийн тодорхойлолт”-ын 8-ын 3-т (тусгай шаардлага ба нөхцөл) ... Тухайн газар суурилуулах хийн болон цахилгаан зуухны нийлбэр чадал нь ажлын даалгаварт заасан утгаас бага байж болохгүй ... гэснийг хийн болон цахилгаан зуух тус тусдаа нийлбэр чадал нь ажлын даалгаварт заасан утгаас бага байж болохгүй гэж ойлгоно.
3	Энэхүү тендер нь ... техникийн шинэчлэлт хийх ажлын ... гэж зарлагдаж байгаа боловч шинээр зуухны, баллоны байрууд барихыг техникийн тодорхойлолтод тусгасан	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/1015 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний нэр тул тендер

байгаа нь өргөтгөл хийх шинжтэй болгож байна. Иймд стандарттай уялдуулж ... шинэчлэлт, өргөтгөл хийх ... гэж нэмж оруулбал болох уу?	шалгаруулалтын үнэлгээний хороо өөрчлөлт оруулах боломжгүй.
--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.